

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар  
сарын 25-ны өдрийн А/259 дүгээр  
тушаалын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2023 он

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН



БАТЛАВ. САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Л.БАЯР-ЭРДЭНЭ

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

Хэрэглээний шинжлэх ухааны сургуульд Дизель  
түвшний лабораторийн засварын ажил

ШУТИС/20240201026

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

|  |    |
|--|----|
| A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....  | 8  |
| 1. Тендерийн цар хүрээ .....   | 8  |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг .....  | 8  |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....  | 8  |
| 4. Худалдан авах ажиллагааны цахим систем .....  | 8  |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх .....  | 8  |
| 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага .....   | 8  |
| 7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага .....  | 9  |
| B. АГУУЛГА .....   | 9  |
| 8. Тендер шалгаруулалтын баримт бичиг .....  | 9  |
| 9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....  | 10 |
| 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....  | 10 |
| 11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах .....   | 10 |
| C. ТЕНДЕР БЭЛТГЭХ .....  | 10 |
| 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл .....   | 10 |
| 13. Тендерийн иж бүрдэл .....  | 11 |
| 14. Тендерийн жишиг маягтууд .....   | 11 |
| 15. Хувилбарт санал .....  | 11 |
| 16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг .....   | 12 |
| 17. Чадавхын болон туршлагын шаардлага .....   | 12 |
| 18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт .....  | 12 |
| 19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ...                                       | 13 |
| 20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг ..... | 13 |
| 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт .....   | 13 |
| 22. Тендерийн валют .....  | 14 |
| 23. Тендер хүчинтэй байх хугацаа .....   | 14 |
| 24. Тендерийн баталгаа .....   | 14 |
| D. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ .....   | 15 |
| 25. Тендер баталгаажуулах, илгээх .....  | 15 |
| 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....  | 15 |
| E. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ .....  | 15 |

|     |  |    |
|-----|--|----|
| 27. | Тендерийн талаар тодруулга авах .....                | 15 |
| 28. | Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх..... | 15 |
| 29. | Тендерийг үнэлэх.....                                | 15 |
| 30. | Арифметик алдааг залруулах .....                     | 16 |
| 31. | Давуу эрх олгох.....                                 | 16 |
| 32. | Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт.....            | 16 |
| 33. | Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....          | 16 |
| 34. | Тендерийг эрэмбэлэх .....                            | 16 |
| 35. | Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....            | 16 |
| E.  | МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ .....            | 17 |
| 36. | Мэдэгдэл хүргүүлэх .....                             | 17 |
| 37. | Гүйцэтгэлийн баталгаа .....                          | 17 |
| 38. | Урьдчилгаа төлбөр .....                              | 17 |
| 39. | Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....          | 17 |

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "ажил" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

### 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

### 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

### 4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.

### 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

### 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаarahгүй.

7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## Б.АГУУЛГА

### 8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3. Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

- 9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.
- 9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.
- 9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.
- 9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.
- 9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.
- 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.
- 10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.
- 11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**
- 11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.
- 11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцочийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

### **14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

### **15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

## **16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн В бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2,

## **17. Чадавхын болон туршлагын шаардлага**

## **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

|   |   |
|---|---|
|   | 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.  |
|   | 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.  |
|   | 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй. |
| <b>19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт</b>                                     | 19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.   |
|   | 19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.  |
|   | 19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.  |
|   | 19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.  |
| <b>20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг</b> | 20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.  |
|   | 20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.  |
|   | 20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.   |
| <b>21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт</b>   | 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.   |
|   | 21.2. Тендерт ирүүлэх өргтийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.  |
|   | 21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг   |

багтсанд тооцно.

21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсэн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэтгэй тэнцүү гэж үзнэ.

21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

## **22. Тендерийн валют**

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## **23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## **24. Тендерийн баталгаа**

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол

тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

### 25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

### 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

### 27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

### 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

### 29. Тендерийг үнэлэх

29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

- 29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцгчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадлан.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн

чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

36. Шийдвэр хүргүүлэх 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
37. Гүйцэтгэлийн баталгаа 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
38. Урьдчилгаа төлбөр 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаарддагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, too хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхжэж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ        |  |
|------------------------|--|
| ТШЗ-ны холбогдох заалт |  |
| ТШЗ 1.1                | Захиалагч: <i>Шинжлэх ухаан технологийн их сургууль</i>  |
| ТШЗ 1.1                | Тендер шалгаруулалтын нэр: <i>Хэрэглээний шинжлэх ухааны сургуульд Дизель түлшний лабораторийн засварын ажил ШУТИС/20240201026</i>   |
| ТШЗ 1.1                | Тендер шалгаруулалтын зарлалтын дугаар: <i>ШУТИС/20240201026</i>   |
| ТШЗ 1.2                | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:<br><i>Багцгүй</i>  |
| ТШЗ 1.3                | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ <i>Үгүй</i> ”   |
| ТШЗ 2.1                | Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Өөрийн хөрөнгө</i>  |
| ТШЗ 2.1                | Нийт төсөвт өртөг: <i>58,900,000 [Тавин найм сая есөн зуун мянган төгрөг]</i>  |
| Б.АГУУЛГА              |  |
| ТШЗ 9.1                | <p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:<br/>Хүлээн авагчийн нэр: <b>СХОА-ны мэргэжилтэн Б.Мөнхцэцэг утас:99180825</b></p> <p>Хаяг: <b>СБД-ийн 8-р хороо, бага тойруу-34, ШУТИС-ийн хичээлийн төө байр 219-3 тоот</b></p> <p>Утасны дугаар: <b>11-324590 /дотуур утас-1037/</b></p> <p>Цахим шуудангийн хаяг: <b><a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a></b></p> <p>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.</p> |

|                          |  |
|--------------------------|--|
| ТШЗ 10.1                 | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үзүү”  |
| <b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b> |  |
| ТШЗ 12.1                 | Тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл.</b>  |
| ТШЗ 15.1                 | Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”   |
| ТШЗ16.1.2                | <p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <b>“Шаардана”</b></p> <p>1. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана</p> <p>2. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаархи хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.</p>  |
| ТШЗ 18.1                 | <p>Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын аль нэг жилд борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна</li> <li>Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.</li> <li>Банк санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна</li> </ol>  |
| ТШЗ 18.2                 | <p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/</li> <li>- Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;</li> </ul> </li> <li>Тендер шалгаруулалтад зарласнаас хойших өдрийн байдлаар Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д</li> </ol> |

|          |  |
|----------|--|
|          | <p>заасан этгээдээс цахим системэр авч тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>3. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.ebalance.mof.gov.mn">www.ebalance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p>   |
| ТШЗ 19.1 | <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Төсвийг Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 12-р сарын 30-ний өдрийн 217 дугаар тушаал Тарифт цалингийн жишгийг шинэчлэн баталсан, Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 2-р сарын 05-ний өдрийн 30 дугаар тушаал “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНБД81-95-12*/2020/-ийн дагуу тооцож Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар гүйцэтгэнэ. Хэрэв хөнгөлөлт тооцсон тохиолдолд үндэслэлийг задаргааны хамт ирүүлнэ</li> <li>2. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг нарийвчлан хийж баталгаажуулан ирүүлэх. Хэрэв туслан гүйцэтгэгчээр болон эсхүл түншлэлийн хэлбэрээр ажлыг хамтран гүйцэтгэхээр тендерт оролцож байгаа бол гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, үнийн дүн, хувь хэмжээг тодорхой зааж ирүүлсэн байх. Ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>3. Тендерт оролцогч нь олон багц ажлын тендерт оролцох болон өөр ижил төстэй ажил гүйцэтгэж байгаа бол зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер техникийн ажилтан, машин механизмуудыг санал болгоно. Энэ тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, машин механизм нь олон багц болон 70 хувиас бага гүйцэтгэлтэй ажилд давхацсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. /80 буюу түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй бол захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ./</li> <li>4. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>5. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. /Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем</li> </ol> |

([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс ажлын З-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу/

Энэхүү тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтэд шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй, эсхүл өөрөөр ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.

Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”

| <i>№</i> | <i>Тоног төхөөрөмж</i> | <i>Тоо ширхэг</i> |
|----------|------------------------|-------------------|
| 1        | <i>Ачааны машин</i>    | 1                 |

Тендерт оролцогч өөрийн эзэмшлийн болон түрээсийн гэрээний дагуу өшиглах машин механизм тоног төхөөрөмжийг цахим систем дэх V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно.

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”

2022, 2023 оны аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”

Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”

|          |  |
|----------|--|
| ТШЗ 19.2 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>[ТШЗ 19.1-д заасан шаардлагыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичгийг хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож бичнэ. Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх;</li> <li>- Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн 4, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</li> <li>- Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшилийн, түрээслэх гэх мэт);</li> <li>- Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.]</li> </ul> |
|----------|--|

|          |  |
|----------|--|
| ТШЗ 19.3 | <p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Үг ажлыг гүйцэтгэхэд эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр доорх тусгай зөвшөөрөл шаардлагатай.</p> <p><b>Барилга, хот байгуулалтын яамны</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил,</b></li> <li>- <b>БА-8.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт</b></li> <li>- <b>БА-7.1- Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил</b></li> </ul> <p>Эдгээрийн аль нэг нь байх</p> <p>Үг ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим системээс шалгана. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй өөрийн зөвшөөрлийн талаар мэдээллийг бүрэн, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг шалгах үүрэгтэй.</p> |
| ТШЗ 21.6 | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тоогтмол байна”   |
| ТШЗ 24.1 | Тендериин баталгааны дүн: “Шаардахгүй”   |

#### Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

|          |  |
|----------|--|
| ТШЗ 25.5 | <p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Хуулийн 7 дугаар зүйлд заасан оролцогчийн ерөнхий шаардлагууд • Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн баримт материал Хуулийн 22.5-ыг үндэслэн ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол ТШЗ-ийн V бүлгийн Маягт-7 дагуу бөглөж ирүүлнэ</p> |
| ТШЗ 26.1 | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2024 он 2 дугаар сарын 23 өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>  |
| ТШЗ 26.2 | <p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2024 он 2 дугаар сарын 23 өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 30 минут</b></p>  |

|  |   |
|--|---|
|  | Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>УБ хот СБД-ийн 8-р хороо, бага тойруу-34, ШУТИС-ийн хичээлийн төв байр 2 дугаар давхарт 214 тоот</b> |
| <b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>       |   |
| ТШЗ 32.1                                     | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үзүй”   |
| <b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b> |   |
| ТШЗ 37.1                                     | Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Үзүй”   |
| <b>Ё. БУСАД</b>                              |   |
| ТШЗ 38.1                                     | Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “үзүй”  |

### **III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

[Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөө), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, эсхүл барааны техникийн тодорхойлолт, эсхүл бусад холбогдох технологийн тодорхойлолтыг боловсруулж, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцөнө.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардлагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бух бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлсан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

## *Зураг төсөл, загвар зураг*

Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана. Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм, журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийвчлан заасан байна.

### *Шалгалт, туршилт*

Захиалагч тендерт оролцогчоос тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохицуулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохицуулгыг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.

### *Үе шатны ажлын хуваарь*

Ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана.]

БАТЛАВ. САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ



Л.БАЯР-ЭРДЭНЭ

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилгын ажлын техникийн тодорхойлолт нь Барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ техникийн баримт бичгийн үндсэн бүрдэл хэсэг болох манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Барилгын норм, дүрэм”, стандарт, техникийн нөхцлийг иж бүрэн баримтална.

Тендерийн нарийвчилсан үнэлгээнд төсвийн тооцооны бодит байдал, ажлын үнэлгээний сонголт, ажлын хөдөлмөр зарцуулалтын дүн, түүний ажил гүйцэтгэх графиктай уялдсан байдал, зааснаас илүү, дутуу тооцсон эсэх зэргийг нарийвчлан хянаж дүгнэнэ.

Төсвийн тооцоонд цалин, материал, тээвэр, механизмын зардал, магадлашгүй ажил, нормчлолын сан, бусад шууд зардал, нэмэгдэл зардал, ашиг, захиалагчийн техник хяналтын зардал, нэмэгдсэн өртгийн татвар, зэргийг улсын хэмжээнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм дүрэм, заавар, тушаал шийдвэрийг үндэслэн зохионо.

Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Бүх бараа материал нь шинэ, ашиглагдаагүй, олон улсын стандартад нийцсэн байна.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

Засвараас гарсан хог хаягдлыг тухайн дүүргийн зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэж зайлуулахаар зардлыг тооцож үнийн саналаа ирүүлнэ.

Энэхүү баримт бичгийн Ажлын too хэмжээ гэсэн бүлэгт байгаа ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Ажлыг гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.

Материалын сонголт өнгөний шийдлийг бодит загвараар нь үзүүлж захиалагчын саналыг тусгана.

**Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:**

- Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график

Заслын ажилд ашигладах материал нь дараах шаардлагыг хангасан байна.

**Цонх:**

- Вакуум цонх 72мм-80мм хуванцар (PVC) өргөн рамтай, 2 давхар вакум шилэн багцтай, өөрөөсөө дарагч резин жийрэгтэй материал, олон улсын чанарын үзүүлэлтүүдийг хангасан -50оС, +50 оС-ийн температурт

**тэсвэртэй, ус цаг уурын элэгдэлд орж хатаж, хугарч, тасарч, хөлддөггүй сайн чанарын резин жийрэгүүдтэй**

**Хаалга:**

- Гадна хаалга нь 1,5 мм цайрдсан цагаан листэн төмөртэй, хуурай технологийн цельсийн 220 градуст хатааж бэхжүүлсэн будантай, эргэн тойрон давхар резинэн жийрэгтэй, 5 см чулуун базальтан дулаалга , дуу тусгаарлагчтай, шилэн гэгээвчтэй, татуургб тайвширууланчтай байх. Монгол улсад үйлдвэрлэгдэж байгаатай дүйцэхүйц чанартай байх
- Дотор хаалга нь: модон 2 хавтастай хаалга байна.

**Заслын материал:**

- Хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан байна.

**Гэрэлтүүлэгч:**

- Заслын ажилд солигдох бүх төрлийн гэрэл нь хүчин чадал, хэлбэр, загвар дизайны хувьд адилгүй ч LED гэрэлтүүлэг байна.

**Цахилгааны монтаж:**

- Гэрлийн тэжээлийн хана ,таазаар суваг ухаж далд татна

**Шал:**

- Хуучин модон шалыг хуулж , бетон тэгшилгээ хийгээд химиийн бодисонд тэсвэртэй сайн чанарын цайвар саарал өнгийн резинэн будгаар будна

**Агааржуулалт:**

- Лабораторийн туршилтын явцад ууршилт явагдах тул агааржуулалт 570м3/цаг бүхий дундын сэнстэй агааржуулалт шинээр хийнэ.

**Шилэн хана:**

- Хуванцар хана, хаалгатай угсрах

**Зургаа. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

Ажлын төсөвт өртгийг тооцоходоо ажлын тоо хэмжээний жагсаалтанд өгөгдсөн хэмжээгээр тооцох ба техникийн тодорхойлолтод заагдсанаар гүйцэтгэнэ.

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

## БУУЛГАХ АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр  | Нэгж      | Тоо хэмжээ |
|-----|--|-----------|------------|
| 1   | Хуучин шалыг задлаж буулгах                      | м2        | 108.68     |
| 2   | Явган ханыг задлаж буулгах                       | м2        | 28.98      |
| 3   | Дүүжин таазыг ховхлож унагах                     | м2        | 83.6       |
| 4   | Хуучин будагтай гадаргууг 100% хусаж цэвэрлэх    | м2        | 202.1      |
| 5   | Тавиургүй цонхыг задлаж буулгах                  | м2        | 13.92      |
| 6   | Хамар ханын хаалга цонхны хайрцаг задалж буулгах | 1хайр-цаг | 2          |

## ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр   | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|---|------|------------|
| 1   | Вакуман цонх угсрах   | м2   | 13.92      |
| 2   | Цонхны зайд завсрьг хөөсөөр чигжиж дулаалах   | м2   | 13.92      |
| 3   | Цонхны чулуун тавиур хавтан суулгах   | м2   | 3.48       |
| 4   | Цонхны амалгаанд замаск хийх  | м2   | 1.44       |
| 5   | Төмөр сараалжин цонхны хаалт буцааж угсрах  | м2   | 13.92      |
| 6   | Тосон будгаар амалгаа будах   | м2   | 1.44       |
| 7   | Замаскан тэгшилгээ 3 р үеийн тэгшилгээ хийх   | м2   | 202.1      |
| 8   | Хана өнгийн тосон будгаар гар аргаар ердийн будах   | м2   | 202.1      |
| 9   | Ердийн нэхцэлд ажиллах дан төмөр каркастай хоёр талаасаа дан хавтан битүү хамар хана угсрах | м2   | 26.4       |
| 10  | Таазыг 35 % хүртэл цэвэрлэж будаг найруулан багсаар ердийн будах                            | м2   | 83.6       |
| 11  | Шилэн хана хаалгатай угсрах   | м2   | 17.5       |
| 12  | Бетоны дэвсгэр үе хийх шалны тэгшилгээ ба тусгаарлалт хийх                                  | м3   | 10.87      |
| 13  | Шал резин будгаар гараар будах  | м2   | 108.68     |
| 14  | Гадна дотор тоосгон хананд 3 м2 хүртэл талбайтай хаалга усрах                               | м2   | 3.68       |
| 15  | 3.6м2 хүртэл талбайтай төмөр хаалга суулгах   | ш    | 1          |
| 16  | 50 мм доош голчтой яндан гэх мэт гадаргууг 2 удаа будах                                     | м2   | 4.67       |
| 17  | Дотор талын 6 м хүртэл өндөр төмөр шат угсрах ба задлах                                     | м2   | 84         |
| 18  | Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд ачих   | м3   | 3          |

## УСАН ХАНГАМЖИЙН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр   | Нэгж  | Тоо хэмжээ |
|-----|---|-------|------------|
| 1   | 25см зузаантай хананд гараар нэвт нүх гаргах. 25мм-ээс дээш голчтой | 1 нүх | 3          |
| 2   | Дотор ус хангамжийн хоолой ф 20 мм                                  | м     | 36         |
| 3   | Хаалт арматурын голч d=25мм байрлуулах                              | ш     | 4          |
| 4   | Усны тоолуур угсрах   | ш     | 2          |
| 5   | Холбох хэрэгсэлийн голч d=20мм тавих                                | ш     | 1          |
| 6   | Бохир усны хуванцар хоолой d-50                                     | м     | 13.5       |
| 7   | Чиг өөрчлөгч угсрах /хуванцар/                                      | ш     | 1          |
| 8   | Угаагуур угсрах/ ком/   | ш     | 1          |
| 9   | Яндан хоолойг дадллах модон хайрцаг хийх                            | м2    | 1          |

## САЛХИВЧИЙН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр   | Нэгж  | Тоо хэмжээ |
|-----|---|-------|------------|
| 1   | Бетон хананд 150мм гүн нүх 100*100мм хийн алхаар гаргах   | 1 нүх | 1          |
| 2   | 150мм хүртэл голчтой хуванцар хоолойг сууринуулсан бэлэн бүтээц дээр хөдөлгөөнгүй бэхэлж угсрах | м     | 11         |
| 3   | Агаар дамжуулах дугуй отголтой хоолойн чиг өөрчлөгчийг хийх, хоолойн голч d=150мм               | ш     | 3          |
| 4   | Вентиляторын агрегат байрлуулах   | ш     | 1          |

## ЦАХИЛГААНЫ АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|-----|-----------|------|------------|
|     |           |      |            |

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

|    |  |        |     |
|----|--|--------|-----|
| 1  | 3 фазын ерөнхий автомат /ВА88-125A/ щитэнд суулгах                             | ш      | 1   |
| 2  | 3 фазын ерөнхий автомат /ВА88-80A/ щитэнд суулгах                              | ш      | 2   |
| 3  | 3 фазын ерөнхий автомат /ВА88-63A/ щитэнд суулгах                              | ш      | 2   |
| 4  | 1 фазын автомат /Lek-32A/ щитний замд суулгах                                  | ш      | 7   |
| 5  | Нойлийн шин /10-тай/ щитэнд тогтоох  | м      | 1   |
| 6  | Шин тусгаарлагч щитэнд тогтоох   | ш      | 1   |
| 7  | Утас /ПУГНП2x4 хананд далд монтаж татах  | м      | 115 |
| 8  | Утас /ПВз1x4 хананд далд монтаж татах  | м      | 140 |
| 9  | Хар хоолой 3 угсрах. д-22 мм <sup>2</sup>                                      | метр   | 30  |
| 10 | Хар хоолой бэхлэж хана, багананд иж бүрэн байдлаар угсрах. д-16мм <sup>2</sup> | метр   | 150 |
| 11 | Утас далдлагч 20x10  | метр   | 8   |
| 12 | Үнтраалга нэг түйт /10A/ далд кропонд суулгах                                  | ширхэг | 2   |
| 13 | Үнтраалга хоёр түйт /10A/ далд кропонд суулгах                                 | ширхэг | 1   |
| 14 | Кропп хананд ухаж суулгах  | ш      | 7   |
| 15 | Розетка далд угсрах  | ш      | 7   |
| 16 | Хананд суваг ухах /0,4-0,6см утас хөвөх /                                      | 100м   | 0.2 |
| 17 | LED прожектор /150Вт/ таазанд тогтоох  | ширхэг | 9   |
| 18 | Зфазын автоматны шин тогтоох   | м      | 3   |
| 19 | 3 фазын тоолуур угсрах   | ш      | 1   |
| 20 | Тросс  | м      | 27  |
| 21 | Тоостой, чийгтэй байранд улайсах ламптай гэрэлтүүлэгч өлгөж угсрах             | ширхэг | 1   |
| 22 | Кропп хананд ил суулгах  | ш      | 1   |

## IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн санаалаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

### 1. Ажил дуусгах хугацаа: [ “Ашиглахгүй” ]

Хэрэв “ашиглах” бол: *Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай*. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бичих]**-аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас **[тоо бичих]**-аас илүү **[“cap”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих]** хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

### 1. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: [ “Ашиглахгүй” ]

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

### 2. Байгаль орчинд нөлөөлөх байдал: [ “Ашиглахгүй” ]

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]**

### 3. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: [ “Ашиглахгүй” ]

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]**

4. Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлж болно.

## **V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ**

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

## Маягт 1. Тендер илгээх

[огноо]

### [Шинжлэх ухаан технологийн их сургууль]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [Хэрэглээний шинжлэх ухааны их сургуульд Дизель түүшний лабораторийн засварын ажил ШУТИС/20240201026] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маяг)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо] өдрийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зэрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:*

**Хаяг:**

## Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

| Албан тушаал | Ажилтны нэр | Боловсрол, мэргэжлийн ур чадвар | Нийт ажлын туршлага, жилээр | Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр |
|--------------|-------------|---------------------------------|-----------------------------|---|
|              |             |                                 |                             |   |
|              |             |                                 |                             |   |
|              |             |                                 |                             |   |
|              |             |                                 |                             |   |

## Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

| Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Хүчин чадал | Тоо ширхэг | [“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих] |
|---|-------------|------------|--|
|   |             |            |  |
|   |             |            |  |
|   |             |            |  |
|   |             |            |  |

## Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|--------------|---|--------------|----------------------------|
|              |   |              |                            |
|              |   |              |                            |
|              |   |              |                            |
|              |   |              |                            |

**Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|--------------|---|--------------|-----------------------|---|----------------|
|              |   |              |                       |   |                |
|              |   |              |                       |   |                |
|              |   |              |                       |   |                |
|              |   |              |                       |   |                |

## Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

|    |   |
|----|---|
| 1. | Захиалагчийн нэр  |
| 2. | Гэрээний нэр  |
| 3. | Гэрээний дугаар   |
| 4. | Гэрээ байгуулсан огноо  |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо  |
| 6. | Гэрээний дүн  |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил   |
|    | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br><input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч |

### **Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

|    | <b>Нууцалсан баримт бичиг,<br/>мэдээлэл</b> | <b>Нууцалсан хууль зүйн үндэслэл</b> |
|----|---|--------------------------------------|
| 1. |   |                                      |
| 2. |   |                                      |
| 3. |   |                                      |
| 4. |   |                                      |
| 5. |   |                                      |

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж ажил гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:

- 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
- 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
- 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
- 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
- 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
- 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
- 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

|                            |        |   |
|----------------------------|--------|---|
| Тайлбар                    | 1.2.   | Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:   |
|                            | 1.2.1. | Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.   |
|                            | 1.2.2. | Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.   |
|                            | 1.2.3. | Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана. |
|                            | 1.2.4. | Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.   |
|                            | 1.2.5. | Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсэн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.   |
| <b>ХОЁР. ЗАХИАЛАГЧ</b>     |        |   |
| Захиалагчийн нийтлэг үүрэг | 2.1.   | Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.  |
|                            | 2.2.   | Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.   |
|                            | 2.3.   | Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.  |
| Захиалагчийн төлөөлөгч     | 2.4.   | Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.  |
|                            | 2.5.   | Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.  |
|                            | 2.6.   | Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр буссад шилжүүлэхийг хориглоно.  |
| Талбайд зөвшөөрөл          | 2.7.   | Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.  |
|                            | 2.8.   | Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.  |

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- |                                       |  |
|---------------------------------------|--|
| Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг           | 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцуулэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.<br>3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.<br>3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.<br>3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.<br>3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.<br>3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.<br>3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй. |
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч               | 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.<br>3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.  |
| Техникийн болон ажлын талбайн өгөгдөл | 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.<br>3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогоеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.  |
| Ажлын талбайн харуул хамгаалалт       | 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.<br>3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.   |

|                                |       |   |
|--------------------------------|-------|---|
| Хог, хаягдал ба нөхөн сэргээлт | 3.14. | Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.  |
| Археологийн бусад олдвор       | 3.15. | Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.  |
| Археологийн бусад олдвор       | 3.16. | ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.   |
| Аюулгүй байдал                 | 3.17. | Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө. |
| Аюулгүй байдал                 | 3.18. | Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.  |
| Аюулгүй байдал                 | 3.19. | Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.   |
| Аюулгүй байдал                 | 3.20. | Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.   |
| Аюулгүй байдал                 | 3.21. | Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.  |
| Аюулгүй байдал                 | 3.22. | Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.   |
| Аюулгүй байдал                 | 3.23. | Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.   |
| Аюулгүй байдал                 | 3.24. | Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.   |
| Аюулгүй байдал                 | 3.25. | Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.   |

#### ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

|            |      |   |
|------------|------|---|
| Ажил эхлэх | 4.1. | Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.   |
| Ажил эхлэх | 4.2. | Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.                     |
| Ажил эхлэх | 4.3. | Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны өрөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын |

- |                           |   |
|---------------------------|---|
|                           | <p>үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.</p> <p>4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.</p>   |
| <b>Хугацаа сунгах</b>     | <p>4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> <li>4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;</li> <li>4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;</li> <li>4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;</li> <li>4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.</li> </ul> <p>4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.</p> <p>4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.</p> <p>4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> |
| <b>Ажлын явцын тайлан</b> | <p>4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</p> <p>4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.</p>  |

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- |                     |   |
|---------------------|---|
| <b>Гэрээний үнэ</b> | <p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> |
|---------------------|---|

- |                   |  |
|-------------------|--|
| Урьдчилгаа төлбөр | <p>5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p>  |
| Төлбөрийн нөхцөл  | <p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сутгана.</p> |

#### **ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА**

- |                               |   |
|-------------------------------|---|
| Урьдчилгаа төлбөрийн баталгаа | <p>6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.</p>  |
| Гүйцэтгэлийн баталгаа         | <p>6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.</p> <p>6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</li> <li>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</li> </ul> <p>6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.</p> |

- |  |  |
|--|--|
|  | <p>6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.</p> <p>6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.</p>   |
| <b>Чанарын баталгаа</b>                      | <p>6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.</p> <p>6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг сутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.</p> <p>6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> |
| <b>Баталгаат хугацаа</b>                     | <p>6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.</p>   |
| <b>ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ</b>              |  |
| <b>Бусдад учруулсан<br/>хохирлыг арилгах</b> | <p>7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p>   |
| <b>Захиалагчийн хүлээх<br/>эрсдэл</b>        | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p>   |

- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын догоолдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэлх хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

#### **НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ**

- Догоолдлыг илрүүлэх, арилгах
- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, догоолдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, догоолдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, догоолдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, догоолдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, догоолдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Догоолдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц догоолдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Догоолдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, догоолдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, догоолдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

- |  |   |
|--|---|
| <p>Далд доголдол</p> <p>Зураг төслийн доголдол</p>             | <p>8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.</p> <p>8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.</p> <p>8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.</p>   |
| <p><b>ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ</b></p>                                |   |
| <p>Захиалагч гэрээг цуцлах</p> <p>Гүйцэтгэгч гэрээг цуцлах</p> | <p>9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> <p>9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;</p> <p>9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гаралгүй;</p> <p>9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;</p> <p>9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.</p> <p>9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нэхцэлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нэхцэлийг хангахгүй болсон.</p> <p>9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.</p> <p>9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> <p>9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;</p> <p>9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> |

- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
  - 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
  - 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
  - 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
  - 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

## АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
  - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
  - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

Төлөөлөгч өөрчлөгдөх

Ажилд өөрчлөлт,  
залруулга хийх нөхцөл

- |   |  |
|---|--|
| <p>Гэнэтийн давагдашгүй шинжтэй онцгой байдал</p> | <p>буюу хүчний нэхцэл</p> <p>10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нэхцэл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.</p> <p>10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p>   |
| <p>Оюуны өмчийн зөрчих</p>                        | <p>10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нэхцэл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p>   |
| <p>Алданги</p>                                    | <p>10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> <p>10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.</p> <p>10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.</p> |

**Маргаан шийдвэрлэх**

- 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцэж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

|            |   |
|------------|---|
| ГЕН 4.1.   | Ажил эхлэх хугацаа: <b>Гэрээнд заасан өдөр</b>  |
| ГЕН 4.2.   | Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хетэлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <b>Гэрээ байгуулах өдөр</b>   |
| ГЕН 4.9.   | Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>   |
| ГЕН 5.2.   | Үнийн тохируулга: “Хийхгүй”   |
| ГЕН 5.4.   | Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”<br><b>Хэрвээ урьдчилгаа төлбөр олгох бол:</b><br>Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <b>[мөнгөн дүн бич]</b>                                      |
| ГЕН 5.5.   | Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: <b>[ажлын хоног бичих]</b>   |
| ГЕН 5.6.   | Төлбөр төлөх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b> Нэхэмжлэл ирүүлсэнээс хойш ажлын 5 хоногт<br>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: <b>[он, сар, өдөр]</b> |
| ГЕН 6.1.   | Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <b>[мөнгөн дүн бич]</b><br>Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>   |
| ГЕН 6.7.   | Чанарын баталгаа:<br>Чанарын баталгаа шаардах эсэх: “Шаардана”<br><b>Албан бичгээр мэдэгдэл ирүүлнэ</b>   |
| ГЕН 6.13.  | Баталгаат хугацаа: <b>1 жил</b>   |
| ГЕН 7.5.   | Даатгал:<br><b>[Ажлын онцлогийг харгалзан гарч болох эрсдэлийг тодорхойлон<br/>Гүйцэтгэгчийн даатгуулах даатгалуудыг нэрлэн бичих]</b><br><b>Гүйцэтгэгч бүрэн хариуцна.</b>     |
| ГЕН 10.21. | Захиалагчийн төлөх алдангийн хувь:<br>Алдангийн хувь: <b>хоног тутамд 0.5 хүртэл хувиар</b>   |
| ГЕН 10.22. | Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:<br>Алдангийн хувь: <b>хоног тутамд 0.5 хүртэл хувиар</b>  |

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

.....  
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
  - 3.7. Техникийн тодорхойлолт;
  - 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнэ. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

**4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл**

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА